



ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УДИРДЛАГЫН ТУХАЙ АНХДАГЧ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

АГУУЛГА

**ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УДИРДЛАГЫН ТУХАЙ АНХДАГЧ
ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

**НЭГ.ХУУЛИЙН ТӨСЛИЙН УЛСЫН ТӨСӨВТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ
ТООЦСОН БАЙДАЛ**

**ХОЁР.ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭД, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫГ
ТООЦСОН БАЙДАЛ**

2.1.ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДАЛ

2.2.ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ

2.3.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДАЛ

ГУРАВ.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УДИРДЛАГЫН ТУХАЙ АНХДАГЧ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4-т уг хуулийн 18 дугаар зүйлд¹ заасны дагуу хуулийн төслийг хэрэгжүүлснээр гарах зардлын тооцоог хийхээр заасан.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төслийг /цаашид “хуулийн төсөл” гэх/ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан **Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал** /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход дор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан болно:

- гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 болон Аргачлалын 1.5-д заасны дагуу хуулийн төсөл батлагдсан тохиолдолд:

1. **Улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл;**
2. **(i) хуулийн этгээдэд (ii) иргэнд болон (iii) төрийн байгууллагад** гарах зардлыг тооцов.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төслийг анхдагч хуулийн төсөл хэлбэрээр боловсруулсан байна. Хуулийн төсөлд улсын төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцож, иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад шинээр болон өмнө гүйцэтгэж байсан үүргээс өргөжүүлсэн чиг үүргийн хүрээнд үнэлгээг хийнэ.

Түүнчлэн хуулийн төслөөр зөвхөн шинээр бий болж буй үүрэгт зардал тооцогдож байгаа тул бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдолд аргачлалын 2.5.2, 4.4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, баримжаалах, салбарын

¹ 18.1.Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийг баталснаар үүсэх зардлын тооцоог гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу дараах байдлаар үнэлж, тодорхойлно:

18.1.1.хууль тогтоомжийн төслийн улсын төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцох;

18.1.2.хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг тооцох."

мэргэжилтнүүдээс санал авах зэргээр хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтоосон болно.

Хуулийн төсөл нь хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд нийгэм, эдийн засгийн дэд бүтцийг бүрдүүлэхэд төсвийн хөрөнгө оруулалтын төслийн төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, хөрөнгийн удирдлага, ашиглалтыг ил тод, үр ашигтай хэрэгжүүлэхтэй холбогдуулан төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын эрх зүйн нэгдмэл орчныг бүрдүүлэх зорилготой бөгөөд аргачлалд заасны дагуу хуулийн төслийн зохицуулалтаар шинээр орж байгаа чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцсон болно.

Тус хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлан чиглэгдэх болно.

Нөгөө талаасаа энэхүү хуулийн зохицуулалт бий болсноор улсын төсөвт урт хугацаандаа ямар ач холбогдол, үр ашиг бий болох, хувийн хэвшилд төсөл хэрэгжүүлэх эхний хугацаанд хөрөнгө оруулалтын зардлууд гарах ч урт хугацаандаа улс орны эдийн засагт үр өгөөжийг бий болгох, хэрэглэгчид хүртээмжтэй төрийн үйлчилгээг хүргэснээр иргэнд гардаг зардлууд буурах боломжийг судлах, хувийн хэвшлийн бизнесийн үйл ажиллагаа өргөжих, ажлын байрны тогтвортой байдлыг хангах, улмаар төсөвт ирэх ачаалал буурах боломжийг судалгаагаар гаргаж харуулахыг зорьсон болно.

НЭГ.ХУУЛИЙН ТӨСЛИЙН УЛСЫН ТӨСӨВТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ ТООЦСОН БАЙДАЛ

Хууль тогтоомжийн тухай хуульд 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдөр “зарчмын” шинжтэй нэмэлт, өөрчлөлт орсон. Уг нэмэлт, өөрчлөлтөөр Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг тооцохын зэрэгцээ хууль тогтоомжийн төслийн улсын төсөвт үзүүлэх нөлөөллийг нэмж тооцохоор болсон.

Үүнтэй холбоотойгоор Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-д нэмэлт, өөрчлөлт ороогүй буюу хууль тогтоомжийн төслийн улсын төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцох аргачлал хараахан батлагдаагүй байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн дээрх нэмэлт, өөрчлөлт 2025 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс үйлчилж эхэлсэн тул Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгад “улсын төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцох” талаар хэрхэн тусгасныг судлан үзэв.²

- Хуулийн төслийн үзэл баримтлалын “1.2. Практик хэрэгцээ, шаардлага” хэсэгт “Хууль тогтоомжийн төсөлд зардлын тооцоог илүү өргөн хүрээтэй хийхээр зохицуулах бөгөөд тухайн төсөл батлагдсанаар улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл, тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардал, хууль тогтоомжийн төслийг батлан хэрэгжүүлснээр эдийн засагт үзүүлэх нөлөөллийг үнэлж, тооцох зохицуулалтыг тусгах нь зөв гэж үзэв. Ингэснээр тухайн төслийн зардлын тооцоог илүү бодитой гаргах, хууль батлагдсаны дараа хэрэгжилтийг улсын төсөв, эдийн засгийн бодлоготой нийцүүлэн хангах боломж бүрдэх юм.” гэж;
- Хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгад “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг илүү өргөн хүрээнд буюу төсөв, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг тооцохоор тусгав.” гэжээ.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлал, дэлгэрэнгүй


² <https://d.parliament.mn/tusul/e599d51b-9e52-46ca-b89e-38c1236918dd>

танилцуулгад тусгагдсан гол агуулгыг баримтлан Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төслийн улсын төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцов.

Төсвийн хөрөнгө оруулалт нь хувийн хөрөнгө оруулалтаас ялгаатай бөгөөд улсын төсөв буюу татвар төлөгчдөөс бий болсон хөрөнгийг оновчтой хуваарилж, үр ашигтай хэмнэлттэйгээр эдийн засаг, нийгмийн дэд бүтэц, үйлчилгээг хангаж төрийн болон орон нутгийн өмчийг бий болгоход чиглэдэг.

Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалт нь улсын төсөв, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан /ОНХС/, гадаадын зээл, тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэл ТХХТ/концессын эргэн төлөлт, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төсөв, Засгийн газрын тусгай сан болон санхүүгийн бусад эх үүсвэр хамаарах боловч Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төслөөр улсын төсөв, орон нутгийн төсөв, ОНХС, гадаадын зээл, тусламжийн төслүүдийн талаар зохицуулсан байна.

**График 1.Төсвийн хөрөнгө оруулалт
2016-2025 /эх үүсвэрээр, тэрбум.төг**



Дээрх графикаас үзэхэд төсвийн хөрөнгө оруулалт Монгол Улсын Нэгдсэн төсвийн нийт зарлагын дунджаар 23.9 хувь, ДНБ-ий дунджаар 8.3 хувийг тус тус эзэлдэг. Монгол Улсын хэмжээнд төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын харилцааг зохицуулсан бие даасан хууль байхгүй бөгөөд суурь харилцааг Төсвийн тухай хуульд голчлон зохицуулж, хөрөнгө оруулалтын төслийн

төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, гүйцэтгэл, хяналт, тайлагналттай холбоотой зарчмын шинжтэй чухал асуудлууд холбогдох бусад хууль тогтоомж болон Засгийн газар, Сангийн сайдын баталсан журам, аргачлалуудаар зохицуулагдаж байна.

Эдгээр хууль тогтоомж хоорондын уялдаа холбоог сайжруулж, журмаар бус хуулиар зохицуулах, хууль зүйн хийдлийг арилгаж, төвсийн хөрөнгө оруулалтын удирдлагын нэгдсэн зохицуулалтыг бий болгох нь төвсийн хөрөнгө оруулалтын оновчтой, үр ашигтай эрх зүйн орчныг бүрдүүлэх, улмаар эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой.

Төвсийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төсөлд төвсийн хөрөнгө оруулалтын төслийн хамрах хүрээ, хэрэгжүүлэх хугацаа, төрөл, ангилал, төрийн байгууллагын чиг үүрэг, мөн төслийн нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийг тооцох, үнэлэх, эрэмбэлэх, шалгуур үзүүлэлт, тавигдах шаардлага болон хориглох зүйлсийг тусгайлан зохицуулсан. Эрх зүйн нэгдсэн зохицуулалт бүрдсэнээр аливаа нэмэлт зардал үүсэхээс сэргийлж, төвсийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын нөлөө, өгөөжийг дээшлүүлэх боломж бүрдэх юм.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Төвсийн хөрөнгө оруулалтын төслийг төсөвт өртөг, хэрэгжих хугацаанд үндэслэн дараах байдлаар ангилна” гэж, мөн 18 дугаар зүйлийн 18.2-т “Төвсийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр дараах зорилго, зориулалт бүхий төслийг хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан. Үүнтэй нийцүүлэн санхүүжилтийн эх үүсвэр, төсөвт өртөг, хамрах хүрээ, төслийн төрөл зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан 2016–2024 онд хэрэгжсэн төслүүдийн судалгаанд үндэслэн ангиллыг боловсруулсан болно.

Ингэснээр орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвөөр 20 тэрбум төгрөг хүртэл (I-II ангилал) жижиг, дунд төслүүд, харин улсын төвсийн хөрөнгө оруулалт болон гадаадын зээлийн санхүүжилтээр 5 тэрбум төгрөгөөс дээш өртөгтэй дунд болон түүнээс дээш ангиллын төслүүдийг хэрэгжүүлэх зохицуулалт бүхий тогтолцоо бүрдэхээр байна.

Энэхүү зохицуулалт нь бага орлоготой аймгуудад санхүүгийн дарамт учруулах эрсдэлтэй боловч урт хугацаандаа тухайн аймгуудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, орлого бүрдүүлэлтийн тогтолцоог сайжруулах, хөрөнгө оруулалтын үр нөлөөг нэмэгдүүлэхэд чухал түлхэц болох юм. Нөгөөтээгүүр, хуулийн төсөлд “20 тэрбум хүртэл” гэсэн тул энэхүү тоон дүн дээд хязгаар бөгөөд заавал 20 тэрбум гэж шаардаагүй, тухайн тоон дүн нь 20 тэрбум хүртэл боломжит дүнгээр байхаар зохицуулагдсан байна.

Хуулийн төслийн 21.1, 21.2-т зааснаар төвсийн хөрөнгө оруулалтын IV, V ангиллын төсөлд заавал, шинэ техник технологи, инноваци нэвтрүүлэх I, II болон

III ангиллын төсөлд шаардлагатай тохиолдолд техник, эдийн засгийн үндэслэл хийхээр тусгасан.

Монгол Улсын 2023-2025 оны төсөв болон 2026 оны төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэх барилга байгууламж болон их засварын ангиллын төслүүдийг доорх ангиллаар авч үзэж доор хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 1: Монгол улсын 2023-2025 оны төсөв болон 2026 оны төсвийн төслийн шинээр хэрэгжүүлэх барилга байгууламж болон их засварын ангиллын төслүүдийн төсөвт өртөгийн ангилал, тэрбум төгрөг

Ангилал	2023		2024		2025		2026	
	Төслийн тоо	Төсөвт өртөг	Төслийн тоо	Төсөвт өртөг	Төслийн тоо	Төсөвт өртөг	Төслийн тоо	Төсөвт өртөг
I	1	0.3	315	795.9	17	36.3	34	97.7
II			136	1,405.8	17	178.5	26	249.1
III	3	126.1	28	1,102.7	19	863.3	15	533.6
IV	1	138.4	4	908.0	5	913.8	5	770.6
V			2	1,239.1				
НИЙТ	5	264.8	485	5,451.5	58	1,991.9	80	1,651.0

Дээрх хүснэгтээс үзвэл 4 жилд IV, V ангиллын 3,969.9 тэрбум төгрөгийн 17 төслийг шинээр хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд энэ нь 1 жилд дунджаар 992.5 тэрбум төгрөгийн 4 төсөл болж байна.

Харин I, II болон III ангиллын 5,389.4 тэрбум төгрөгийн 611 төслийг шинээр хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнээс шинэ техник технологи, инновац нэвтрүүлэх төсөлд хэд нь хамаарах боломжтойг урьдчилан тооцох боломжгүй байна. Нөгөөтээгүүр хууль батлагдаад эхний жилүүдэд IV, V ангиллын төслүүдэд техник, эдийн засгийн үндэслэл хийх асуудалд голлон анхаарч тогтолцоог бүрдүүлэх төлөвтэй байна.

Хуульд техник, эдийн засгийн үндэслэл хийх зардлыг төслийн төсөвт өртөгийн 3%-аас ихгүй байхаар заасан боловч энэ нь дээд хязгаар тул дунджаар 1.5% байхаар тооцвол 1 жилд дунджаар 14.9 тэрбум төгрөгийн техник, эдийн засгийн үндэслэл хийлгэх нэмэлт шаардлага үүсэхээр байна.

Монгол Улсын 2023-2025 оны төсөв болон 2026 оны төсвийн төсөлд Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ” гэсэн төсөл жил бүр 40.0 тэрбум төгрөгөөр тусгагдсан байна. Дээр дурдсан 14.9 тэрбум төгрөгийн техник, эдийн засгийн үндэслэлийг тус төслөөс хэрэгжүүлэх боломжтой гэж тооцоолон нэмэлтээр зардал гарахгүй гэж үзэж байна.

Иймд, дээрх хуулийн төсөлтэй холбогдуулан **улсын төсөвт нэмэлт зардал гарахгүй** болно.

ХОЁР. ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭД, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫГ ТООЦСОН БАЙДАЛ

2.1.ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулиар өмнө нь журам, аргачлалаар зохицуулагдаж байсан харилцааг хуульчилсан нь илүү тогтвортой, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх бөгөөд хуулийн төсөлд хуулийн этгээдэд нэмэлт зардал үүсгэх зохицуулалт тусгагдаагүй, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн байгууллагуудын чиг үүргийг багасгах, хумих, илүү тодорхой болгоход чиглэсэн.

Тухайлбал хуулийн төслийн 30.3 дахь хэсэгт “Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, цахим систем болон зөвлөх үйлчилгээний төслийн санхүүжилтийг энэ хуулийн 10.1.3-т заасан журмын дагуу хэрэгжүүлнэ” гэж, 32.4 дэх хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөлд тавих захиалагчийн техник хяналтыг захиалагч болон гүйцэтгэгчээс хараат бус, мэргэжлийн эрх бүхий этгээдээр хэрэгжүүлж болно” гэж, 32.5 дахь хэсэгт “Төсөл хэрэгжүүлэхэд хийгдэх захиалагчийн техник хяналтыг тендер шалгаруулалтын үндсэн дээр эрх бүхий мэргэжлийн этгээдээр зөвлөх үйлчилгээний гэрээгээр гүйцэтгүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барилга байгууламж, их засварын ангиллын төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,513.5 тэрбум төгрөг батлагдсан. Эдгээр төслүүдийн захиалагч болон зохиогчийн хяналтын зардалд 4 хувь буюу ойролцоогоор 60.5 тэрбум төгрөгийг Барилгын хөгжлийн төв ТӨҮГ, Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ болон Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийг санхүүжүүлсэн бөгөөд энэхүү санхүүжилтийг хувийн хэвшил рүү чиглүүлэх боломж бүрдэх юм.

Түүнчлэн, дээрх хууль хэрэгжсэнээр хуулийн этгээдэд татвар, төлбөр, хураамжийн хэлбэрээр ямар нэгэн шууд мөнгөн төлбөрийн үүрэг оногдуулахгүй бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтын төслийн чанар, шалгуур, үнэлгээний тогтолцоо сайжрах эерэг үр дүнтэй болно.

Мөн хуулийн төслийн 47 дугаар зүйлд төслийн гүйцэтгэгчийг үнэлж, урамшуулах болон хязгаарлах зохицуулалт тусгасан бөгөөд ингэснээр төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, гүйцэтгэгч аж ахуй нэгжүүдийн чадавхыг сайжруулна гэж үзэж байна.

Тодруулбал, гүйцэтгэлийн үнэлгээний жагсаалтыг цахим системд олон нийтэд нээлттэй, ил тод байлгаж сайн гүйцэтгэлтэй буюу “ногоон” үнэлгээтэй аж ахуй нэгжид урьдчилгаа төлбөрийг баталгаагүйгээр санхүүжүүлэх, дундаж гүйцэтгэлтэй буюу “шар” үнэлгээтэй аж ахуй нэгжийн урьдчилгаа төлбөрийн баталгаагаар авах санхүүжилтийн хувь хэмжээг нэмэгдүүлэх бол хангалтгүй гүйцэтгэлтэй буюу “улаан” үнэлгээтэй аж ахуй нэгжийг гүйцэтгэгчийн төрийн худалдан авах ажиллагаанд оролцох эрхийг хязгаарлах боломжтой болсон.

ДҮГНЭЛТ:

Хуулийн төсөлд хуулийн этгээдэд шууд мөнгөн төлбөр ногдуулахгүй бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтын төслийн шинэ шалгуур, үнэлгээний зарчмыг биелүүлэхэд зарим хуулийн этгээдэд нэмэлт ажил, цаг хугацаа, үнэлгээ, баталгаажуулалтын шууд бус зардал гарч болох юм. Гэсэн хэдий ч энэхүү үнэлгээний систем нь төслийн чанар, аюулгүй байдал, үр өгөөжийг дээшлүүлэх боломжтой болно.

2.2. ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ

ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ: Хуулийн төсөлд иргэнд шууд зардал үүсгэсэн зохицуулалт байхгүй. Харин олон нийтэд төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийг ил тод мэдээлэх зохицуулалтууд /24.3, 34.2, 35.3, 36.4, 36.7, 37.1, 42.1, 46.4, 47.3 гэх мэт/-ын дагуу иргэд төсвийн хөрөнгө оруулалтын үйл явцад оролцох, хянах боломжтой болно.

24 дүгээр зүйл.Төслийг үнэлж, эрэмбэлэх

24.3.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслийн шаталсан үнэлгээг энэ хуулийн 24.2-т зааснаар хийсэн талаарх тайлан болон төсвийн төсөлд тусгах төслийн нэгдсэн жагсаалтыг цахим системээр ил тод, нээлттэй мэдээлнэ.

34 дүгээр зүйл.Тайлагналт, үр дүн

34.2.Төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж төслийн санхүүжилтийн талаарх мэдээллийг цахим системд ил тод тогтмол мэдээлж, санхүүжилт хийгдэх бүрд мэдээллийг шинэчилнэ.

35 дугаар зүйл.Мэдээллийн сан, ил тод, нээлттэй байдал

35.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мэдээллийн санг бүрдүүлэх, цахим системд мэдээллийг ил тод, нээлттэй байлгах нөхцөлийг хангаж ажиллана.

36 дугаар зүйл.Олон нийтийн оролцоо

36.4.Төсвийн ерөнхийлөн захирагч, захиалагч нь төслийн хэрэгжилт болон хяналт, тайлагналтын талаарх мэдээ, тайлан, дүгнэлтийг байгууллагын цахим хуудсаар тухай бүр олон нийтэд мэдээлнэ.

36.7.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд олон нийтийн оролцоог хангах, төслийн хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлэх хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийг төлөвлөхөд цахим системээр иргэдийн саналыг авах, тусгах, уялдуулах арга хэмжээг зохион байгуулна.

37 дугаар зүйл.Цахим системийн удирдлага, зохион байгуулалт

37.1.Төсвийн хөрөнгө оруулалтыг их өгөгдөл ашиглан, хиймэл оюун ухаанд тулгуурлан төлөвлөх, төслийг үнэлэх, сонгох болон хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах, өмчид бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх, хадгалах, мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй хүргэх үйл ажиллагааг төсвийн хөрөнгө оруулалтын цахим системээр хэрэгжүүлнэ.

42 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын хөрөнгийн үр өгөөж

42.1.Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төслийн үр дүн, хөрөнгийн ашиглалт, түүний үр өгөөжийг энэ хуулийн 11.1.6-д заасан аргачлалын дагуу тооцож, үнэлэх бөгөөд үнэлгээний тайланг цахим системд тайлагнана.

46 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сангийн ил тод байдал, тайлагналт

46.4.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сангийн орлого төвлөрүүлэлт, хөрөнгийн зарцуулалт, ажлын тайлан, үр дүнг Засгийн газарт танилцуулж, цахим системд ил тод, нээлттэй байршуулна.

47 дугаар зүйл.Төслийн гүйцэтгэгчийг үнэлэх

47.3.Төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэгчийг энэ хуулийн 47.1, 47.2-т заасны дагуу үнэлсэн жагсаалт нь цахим системд олон нийтэд нээлттэй, ил тод байна.

ДҮГНЭЛТ:

Хуулийн төсөлд иргэнд шууд төлбөр, шимтгэл ногдуулах зохицуулалт тусгагдаагүй болно.

Харин хуулийн төслийн төсвийн хөрөнгө оруулалтад иргэдийн оролцоог хангах, олон нийтэд ил тод мэдээлэхтэй холбоотой заалтуудын дагуу иргэн төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд оролцох, хяналт тавих, санал өгөх боломжийг бүрдүүлнэ. Эдгээр оролцоо, хяналтын үйл ажиллагаа нь сайн дурын үндсэн дээр хэрэгжих бөгөөд иргэнд ямар нэгэн санхүүгийн дарамт, зардал үүсгэхгүй.

Мөн хуулийн төсөлд мэдээлэл, хяналт, оролцоог цахим хэлбэрээр үнэ төлбөргүйгээр хангах зохицуулалт тусгагдсан нь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, ил тод байдлыг хангах, хяналтын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэнэ.

2.3.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДАЛ

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төсөл нь төрийн байгууллагын одоогийн бүтэц, зохион байгуулалт, санхүүгийн болон хүний нөөцийн чадавх, төрийн мэдээллийн системийн суурь дэд бүтэц дээр үндэслэн хэрэгжих боломжтой юм.

Хуулийн төсөлд төрийн захиргааны байгууллагын бүтэц, үйл ажиллагаанд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэ зардал бий болгох зохицуулалт тусгагдаагүй болно.

Аргачлалын шаардлагын дагуу дүн шинжилгээний хүснэгт

Зардлын төрөл	Зардал гарах эсэх	Үндэслэл
Хүний нөөц	Үүсэхгүй	Төрийн байгууллагуудын хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжийн бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдөхгүй.
Мэдээллийн систем	Үүсэхгүй	Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем /PIMIS/-ээр хэрэгжүүлнэ.
Тоног төхөөрөмж	Үүсэхгүй	Одоогийн сервер худалдан авах, дата төв байгуулж, өргөтгөх шаардлагагүй.
Сургалт	Үүсэхгүй	Цахим сургалт, дотоод нөөц

ДҮГНЭЛТ:

Аргачлалын дагуу бүх зардлын ангиллыг үнэлэхэд, хуулийн төсөл нь төрийн байгууллагын одоо байгаа бүтэц, хүний нөөц, төсвийн хүрээ, төрийн цахим дэд бүтэц болон сургалтын цахим платформ дээр тулгуурлан бүрэн хэрэгжих боломжтой бөгөөд нэмэлт зардал шаардлагагүй тул төрийн байгууллагын зардлын нөлөөллийг “0 төгрөг” гэж тооцож, аргачлалын шаардлагыг бүрэн хангасан гэж үзэв.

ДӨРӨВ. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалд заасны дагуу хэмжигдэхүйц зардлыг тооцлоо.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төсөл нь улсын төсвийн хэмжээнд шинэ төрлийн хөрөнгө оруулалт, санхүүгийн нэмэлт дарамт, байгууллагын бүтцийн өөрчлөлт, орон тооны өсөлт, мэдээллийн технологийн хөрөнгө оруулалт болон бусад дагалдах зардлыг үүсгэх зохицуулалт тусагдаагүй бөгөөд иргэн, хуулийн этгээд болон төрийн байгууллагад нэмэлт зардал үүсгэхгүй хэрэгжих боломжтой юм.

Хуулийн төсөл нь одоо хүчин төгөлдөр мөрдөж буй эрх зүйн зохицуулалт, төрийн байгууллагуудын бүтэц, төсвийн байгууллагын хүний нөөцийн чадавх, мэдээллийн технологийн дэд бүтэц, санхүүгийн удирдлагын тогтолцоонд тулгуурлан хэрэгжих бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжилт, хяналт, тайлагналын бүх үе шатанд ил тод байдлыг хангах, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх, үр ашгийг дээшлүүлэх, төсвийн сахилга бат, зарцуулалтын зохистой байдлыг сайжруулах, давхардал болон үргүй зардлыг системтэйгээр бууруулах суурь нөхцөлийг бүрдүүлэх боломжтой юм.

Ингэснээр “төрийн байгууллагад нэмэлт зардал үүсэхгүй бөгөөд нийт төсвийн үр ашгийг дунд хугацаанд 5–10 хувиар нэмэгдүүлэх боломж бүрдэхээр байна” гэж дүгнэв.

-----oOo-----